

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

2022/03/25-2022-06-25

№	Өргөдөл гомдлын агуулга	Нийт тоо	Хэлбэр						Агуулга				Шийдвэрлэж хариу өгсөн			Шийдвэрлэж байгаа	
			амаар	бичгээр	утсаар	Цахим хэлбэрээр	Дэд байгууллагаас ирсэн	талархал	Санал	хүсэлт	гомдол	мэдэгдэл	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа хэтэрч хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
1	Цахим системд бүртгэгдсэн	168		169				6	162					168			
2	Цахим системд бүртгэгдээгүй	1							1					1			
Нийт		169		169				6	163					169			



ХЯНАСАН
ДАРГА *Ш.Мөнхцэцэг* Ш.МӨНХЦЭЦЭГ
МЭДЭЭ ГАРГАСАН
АРХИВ БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН *Д.ГАНЗАЯА* Д.ГАНЗАЯА

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВД 2022 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 28

Улаанбаатар хот

2022 оны 2 дугаар улиралд иргэдээс 163 өргөдөл, 6 талархал ирснийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж UB ERP систем дэх Өргөдөл гомдлын дэд системд бүртгэсэн. Дээрх өргөдөл, хүсэлтийн 97% нь төвийн байранд орох, гарах хүсэлт, 3%-нь иргэний бичиг баримттай холбоотой хүсэлт, 3,6%-нь талархал байна.

2021 оны 2 дугаар улиралд иргэдээс 55 хүсэлт, 0 талархал, гомдол 0 ирүүлж байсан нь хүсэлт, талархлын тоо өссөн дүнтэй байна.

Тус төв нь нийслэлийн хэмжээнд тэнүүчлэн амьдарч байгаа иргэдийг хүлээн авч нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд дээрх иргэд нь регистрийн дугаараа мэдэхгүй, холбогдох утасгүй, тодорхой оршин суух хаяггүй байдаг нь ERP програмд шивэхэд хүндрэл үүсгэж байна.

Тайлант хугацаанд регистрийн дугаараа мэдэхгүй 1 иргэний өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Мөн дээрх иргэд нь бичиг үсгийн боловсрол муу, сэтгэцийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, архинд донтох өвчтэй, гар утас ашигладаггүй, орон гэргүй учраас тодорхой оршин суух хаяггүй байдгаас шалтгаалан бичсэн өргөдөл шаардлага хангахгүй байх шалтгаан болдог. /Төрийн албан ёсны хэлээр өргөдөл бичих чадваргүй, үг үсгийн алдаа ихтэй/

Нийгмийн ажилтнууд эдгээр иргэдийг хүлээн авч, бүртгэл судалгаа хөтлөн, нийгмийн халамжийн анхан шатны үйлчилгээ үзүүлсний дараа /усанд оруулах, дотуур гадуур хувцсыг нь солих, халуун хоолны үйлчилгээнд хамруулах/ бүртгэлийн анкет хөтлөн, өргөдөл хүсэлтийг хүлээн авч байна.

Өргөдлийн тоо өссөн нь их засварын ажил хийгдэж түр хоноглох байрны орчин, нөхцөл сайжирсан, covid-19 цар тахлын дэгдэлт буурч, шар түвшинд шилжсэнтэй холбоотой байна.

Өргөдөл, гомдол хариуцсан ажилтан нь холбогдох байгууллагаас зохион байгуулагдсан сургалтанд хамрагдаж, ажилтнуудад заавар, зөвлөгөө өгч ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр Хурлаас өгсөн үүрэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 03/3144 дугаартай албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу төвийн удирдлага, хамт олонд сар бүр иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг танилцуулж, өргөдөл, гомдлыг өдөрт нь хүлээн авч танилцан шийдвэрлэж байна.

Тайлант хугацаанд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол үгүй, саналын шинжтэй өргөдөл ирүүлээгүй бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2 цаг 10 минут байгаа нь 2021 оны мөн үеийн шийдвэрлэлтийн хугацаанаас 1 цаг 25 минутаар бага цаг зарцуулсан байна.

2022 оны 2 дугаар улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг байгууллагын цахим хуудсаар мэдээлж, даргын дэргэдэх зөвлөлийн 2022 оны 6 дугаар хурлаар хэлэлцүүлсэн болно.

ТАНИЛЦАН:
ДАРГА *Мөнхцэцэг* Ш.МӨНХЦЭЦЭГ
ТАЙЛАН, МЭДЭЭ ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН *Д.Ганзаяа* Д.ГАНЗАЯА



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ

ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ-ээс

№6

2022 оны 06 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Даргын дэргэдэх зөвлөлийн хурал 201 тоот өрөөнд 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдөр 10:30-11:45 цагийн хооронд болов.

Хуралд

1. Дарга Ш.Мөнхцэцэг
2. Арга зүйч Б.Нандинцэцэг
3. Нягтлан бодогч Б.Энхдолгор
4. Нийгмийн ажилтан Э.Пүрэвсүрэн
5. Сэтгэлзүйч Б.Балцэцэг
6. Архив, бичиг хэргийн ажилтан Д.Ганзаяа нар оролцов.

Хурлыг төвийн дарга удирдан явуулав. Хурлын ирц 80%

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Төвийн 2022 оны эхний хагас жилийн өргөдөл, гомдлын тайлан хэлэлцэх

СОНССОН НЬ:

Д.Ганзаяа: 2022 оны 2 дугаар улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ танилцуулья, 2022 онд 366 өргөдөл, хүсэлт ирүүлсэн, 2 дугаар улиралд 163 өргөдөл, 6 талархал ирүүлсэн нь 2021 оны энэ үеийнхээс өссөн байна. Дээрх мэдээллийг байгууллагын цахим хуудсаар мэдээлсэн. Мөн Нийслэлийн Тамгын газраас өргөдөл, гомдын шийдвэрлэлтийг сайжруулах, хугацаа хэтэрч өргөдөл шийдвэрлэсэн ажилтанд хариуцлага тооцох талаар албан бичиг ирүүлсэн байгаа. Холбогдох байгууллагад мэдээ хүргүүлэх тул та бүхэн уншиж танилцан, саналаа өгнө үү.

Э.Пүрэвсүрэн: Тайлантай танилцлаа. Үг үсэг, утга найруулгын хувьд алдаа байхгүй гэж үзэж байна.

Б. Энхдолгор: Тайланг уншиж танилцсан. Тайланг илгээхэд бэлэн гэж үзэж байна.

Ш.Мөнхцэцэг: Цаашид өргөдөл, гомдлын мэдээг сар бүр ирүүлэх, даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, мэдээлж байх чиг үүрэгтэй ажиллана.

Б.Нандинцэцэг: Та бүхний саналыг тэмдэглэж авлаа. Холбогдох саналыг тусгаж, тайлангаа хүргүүлье.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2022 оны 2 дугаар улирлын мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэх

ТЭМДЭГЛЭЛТЭЙ
ТӨВИЙН ДАРГА



Ш.МӨНХЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
АХЛАХ АРГА ЗҮЙЧ 

Б.НАНДИНЦЭЦЭГ